

Д.Дарьзавын шударгаар хөгжимдөх арга барилд хийсэн шинжлэл

Сосорын Энх-Амгалан

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
ORCID: <https://orcid.org/0009-0002-7310-5535>
Холбоо барих зохиогч: amgalan2023@gmail.com

Хураангуй: Монголын үндэсний хөгжимдүүрээр хөгжимдөх уламжлал, урлахуйн асуудлыг шинжин тодруулах хэрэгцээ шаардлага гарсаар байна. Иймд ХХ зууны дунд үеийн шударгач, ахмад багш Далхжавын Дарьзавын /1933-1985/ хөгжимдөх арга барилыг шинжиж, тайлбарлал хийн, үр дүнг мэдээлэхийг зорьсон болно.

Ингэхдээ Монголын радиогийн алтан санд буй Д.Дарьзавын Монгол Улсын гавьяат багш, ёочинч Г.Дашдаваа, Монгол Улсын гавьяат жүжигчин, хуучирч С.Цэвэлмаа нартай хамсран, хуучирч Л.Балдантай хоршин хөгжимдсөн ардын дуунуудын бичлэгийг сонсож, хөгжимдсөн шударгын хөг хөглөгөө, дууны аялгуу, чимэглэл, хурууны хуваариллыг эгшиг тэмдэглэгээнд мэргэжлийн түвшинд буулган, хөгжимдөлтөд шинжлэл хийж, судалсан болно. Энэхүү судалгааг хийхдээ аялгууг хувилбарлан хөгжимдсөн цохилгын төрлүүд, хурууны хуваарилал, голлох хэмнэл, эгшиг сонголт /атгал/, гулсалт, чимэглэлийн онцлог, эгшиглээний чанар, донж маяг, гүйцэтгэл, ахмад үеэс уламжилсан байдал зэргийг шинжиж, Д.Дарьзавын хөгжимдөх арга барилд өөрийн гэсэн хөгжимдөх онцлог байна хэмээн үзлээ. Ингэж ахмад үеийн шударгачдын ардын дуу хөгжмийг урлан хөгжимдөх уламжлал, арга барил, онцлогийг хүн бүрээр судлан тодруулснаар шударгадах урлагийн уламжлал, урлан хөгжимдөх арга ухааныг сургалт судалгаанд оруулахад онол практикийн ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: ардын дуу, чимэглэл, донж маяг, хэмнэл

Analysis of D.Darizav's performing technique of Shanz (shudarga)

Enkh-Amgalan Sosor

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0002-7310-5535>

Corresponding author: amgalan2023@gmail.com

Abstract: It is still necessary to carry out an in-depth research on the traditional performance technique, style manner and luthiery on the Mongolian national musical instruments.

Therefore, we intended to analyze and study the performing technique of the senior teacher Dalkhjav Darizav, shudarga player of the middle of the 20th century and to inform our study research. We have studied the records of the folk songs jointly performed by Darizav, yochin player G.Dashdavaa, honoured teacher of Mongolia, khuuchir player S.Tselvelmaa, honoured artist of Mongolia and, khuuchir player L.Baldan in the golden fund of the Mongolian radio.

We considered that the performing technique of D.Darizav is distinctive on the basic of our study of his tone of the shudarga, variation, finger distribution, rhythm, type of beat, vowel choice (grip), glides, decoration peculiarity, sound quality and manner.

Shudarga's traditions, methods, and characteristics of the older generations are studied, and it is of theoretical and practical significance to include the traditions of shudarga's art and methods of luthiering music in training and research.

Keywords: *folk song, fioritura, manner, rhythm, shanz*

Оршил

Монголын үндэсний хөгжмөөр хөгжимдөх уламжлалт арга барилын чиглэлээр судалгаа тодорхой түвшинд хийгдэж байгаа бөгөөд түүн дотроо шударгаар хөгжимдөх сургалт, судалгаанд зориулан багш Ц.Дашдулам (1990, 2009), Л.Оюунчимэг (1995, 2005), С.Бүтэд (1999), Р.Оюунбат (2005, 2005), Д.Жаргалмаа (2010), С.Энх-Амгалан (2018, 2018, 2022) нарын гаргасан гарын авлага, судалгааны бүтээлүүд байна. Эдгээр бүтээлүүдэд ардын дууг хөгжимдөх цохилгын тайлбар, томъёолол, ардын дуу хөгжмийн аялгууны эгшиг тэмдэглэгээ, хөгжимдөх хувилбарууд, зарим хөгжимчдийн товч танилцуулга, хөгжимдөх байдалд хийсэн дүгнэлт зэрэг байдаг.

Эдүгээ монголд үндэсний хөгжмөөр хөгжимдөх уламжлалт ардын арга барил/манер/-ын сургалт тогтсон байгаа хэдий ч хөгжимдөх урлахуйн мөн чанар, ойлголт бүдгэрч, мартагдахад хүрч байна. Өөрөөр хэлбэл, уламжлалт арга барилаар хөгжимдөх гэдгийг ардын дуу хөгжмийн ая аялгууг өөрийн дураар хөгжимдөх гэсэн ерөнхий ойлголтоор дүйлгэж, хандаж байгаа нь анхааруштай асуудлын нэг болжээ. Иймд уламжлалт арга барилаар хөгжимдөх гэсэн ойлголтыг урлахуйн ухаантай холбон үзэж, шинжүүдийг тодруулах зорилгын хүрээнд ахмад үеийн

багш нар, алдарт хөгжимчдийн хөгжимдөх арга барилыг нарийвчлан судлах зорилт тавьж байна. Эдгээр хөгжимчин багш нарын нэг нь ХХ зууны дунд үеийн шударгач, ахмад багш Далхжавын Дарьзав /1933-1985/ юм. Д.Дарьзав ардын дуу хөгжмийг өөрийн гэсэн онцлог арга барил, эгшиглээтэй хөгжимддөг нь түүний үлдээсэн бичлэгээс ажиглагдсан ба түүний хөгжимдөх арга ухаан, донж маяг, гүйцэтгэлийг монголын шударга хөгжимчид өндрөөр үнэлдэг билээ. Иймд Дарьзавын хөгжимдсөн ардын дууны таван аудио бичлэгийг эгшиг тэмдэглэгээнд буулган, хөгжимдөлтөд шинжлэл тайлбарлал хийн, үр дүнг анх удаа мэдээлж байгаагаараа энэхүү судалгаа шинэлэг бөгөөд нарийвчлан судлах оролдлогыг хийж байгаад ач холбогдол оршино.

Судалгааны арга зүй

Ахмад шударгач, багш Д.Дарьзавын хувь хүний урлагийн мэдрэмж, зан чанар, шударга хөгжимд суралцсан болон хөгжимдөх байдлыг шавь нар, үр хүүхдүүдтэй хийсэн цуврал ярилцлагаас, мөн монголын радиогийн алтан санд буй ёочинч Г.Дашдаваа, хуучирч С.Цэвэлмаа нарын хамтаар хөгжимдсөн түүний 1960 оны нэг, 1984 онд хуучирч Л.Балдангийн хамтаар хоршин хөгжимдсөн дөрвөн ардын дууны бичлэгийг сонсож шударгын хөг, дууны аялгуу, хөгжимдсөн хувилбаруудыг эгшиг тэмдэглэгээнд буулган, сургалтанд нэвтрүүлэн туршин судалж, цохилгын төрөл, задгай болон битүү жигд эгшиглээ, голлох хэмнэл, чимэглэн, эгшиглээний чанар зэргийг ахмад, алдарт шударгачдын хөгжимдсөн арга барилтай харьцуулан, хөгжимдөх урлагийн талаас шинжиж, тайлбарлал хийн, нэгтгэн дүгнэсэн болно.

Судалгааны үр дүн

Судлаач Л.Оюунчимэг “Манай шударгачид шударгаар монгол ардын дууг хөгжимдөхдөө өөр өөрийн гэсэн өвөрмөц дэг жаягтай байгааг цаашид судлаачид нягтлан үзвээс нэн сонирхол татахуйц ажил болох нь дамжиггүй” (Оюунчимэг 1995, 80) гэж, судлаач Р.Оюунбат “Сэтгэхүйн уран үйлдлийн нэгэн хэлбэр нь дуу хөгжмийн донж маягийн (манерын) тоглол болно. Донж маяг нь хөгжимчин хүний сэтгэхүйн ур хийц, сэтгэх чадвар, чадамжийг харуулах зүйл юм. Тийм ч учраас хүн хүний дуулах, хөгжимдөх нь ялгаатай, тэр ч байтугай нэг дуу хөгжмийг нэг хүн олон янзаар гүйцэтгэдэг” (Оюунбат 2005, 119-120) хэмээн бичсэн байна. АЖ, Төрийн соёрхолт, багш Ц.Дашдулам “Ардын уламжлалт хөгжимдөх арга ухаан ч бас өөрийн гэсэн тусгай дэг сургуультай бөгөөд дуу дагах, хамтран хөгжимдөх, гоцлон хөгжимдөх зэрэгт өөр өөр хэрэг үүргээр ашиглаж ирсэн байна” (Дашдулам 1990, 5) гэж тэмдэглэжээ. Судлаач, багш нарын энэ санааг эдүгээ цагт нягтлан судлахад анхаарууштай болжээ.

Мөн үндэсний хөгжимчдийн ардын дууг хөгжимдөх онцлогийн тухай судлаач Н.Жанцанноров бичихдээ “Монгол ардын хөгжмийн зэмсгийн хөг, дуурьсал, тэдгээрээр хөгжимдөх арга барил монгол хүний хэл, яриа сэтгэхүй, уран сайхны мэдрэмж, сайхныг хүсэх тэмүүлэл, хөгжмийн үндэсний сэтгэлгээ, цомнолын үндсэн хууль, зарчимтай шууд холбоотой юм. Монгол ардын дуу хөгжмийн бүтээлийн уран сайхан илэрхийллийн гол арга нь аялгууг уран гоё нугалаа хугалаагаар баяжуулан, хөгжмийн үндэсний сэтгэлгээний хүрээнд дуучин, хөгжимчин бүр хувь хувийн авьяасыг дэлгэн үзүүлсэн нэг ёсны сайхан ая дууны уралдаан юм. Тийм ч учраас

уртын дуучин бүр өөр өөрийн дуулдаг дэг, сэтгэлгийг бусдаас ялган хадгалж хуурч, хийлч, шударгач бүр өөр өөрийн баян тансаг аялгуу хэмнэлээр бахархдаг. Бид морин хуурчдын тухай ярихдаа дуучдын нэгэн адил Жамьяангийн “Замбуу тив”, Цэдэнгийн “Сэрүүн сайхан”, Буянгийн “Хоёр бор” гэх мэт хөгжимчин дуу хоёрыг салгаж үздэггүй хамтад нь уран сайхны бүтээл болгодог юм. Гэхдээ манай нэрт хөгжимчид хуурчид хийлчдээс, хийлчид шударгачдаас ялгагдах ерөнхий дэг сургуулийг боловсруулан батжуулж чадсан байна. Ийм болохоор хуур хийл, ёочин нийлээд нэгэн дуу хөгжимдөхөд найрал хөгжим болдог юм.

Энэ найрал хөгжим нь зэмсэг болгоноор хөгжимдөх ардын хөгжимчдийн боловсруулсан өөр өөрийн уран сайхны дэг сургуулийн нийлбэр болж “аялгууны симфони” болж хувирдаг байна. Манай ард түмний бүтээсэн, өөрийн нь мах цус, сэтгэл зүрхэнд шингэсэн уран сайхны энэ сэтгэлгээг судлах, сурвалжлах, нэгтгэн дүгнэх, уламжлан суралцах асуудал зөвхөн манай үндэсний соёлын төдийгүй хүн төрөлхтний соёлын нэг өвөрмөц дэгийг хадгалах хамгаалахын тухай асуудал мөн” (Дашдулам 1990, 4) хэмээн тэмдэглэжээ. Үүнийг хөгжимчин, багш бид ухааран ойлгож сургалт судалгаа, уран бүтээлдээ нягт шингээн, хойч үедээ өвлөн уламжлуулж, түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй хэргийн нэг юм. Иймд энэ удаагийн судалгаагаар монголын ХХ зууны эрэгтэй шударгачдын нэг болох ахмад шударгач, багш Д.Дарьзавын хөгжимдсөн арга барилыг авч үзсэн болно.



Зураг 1. Д.Дарьзав

Д.Дарьзав 1933 онд Завхан аймгийн Жавхлант сумын нутагт Далхжавын ууган хүү болон мэндэлсэн. Нийслэлийн арван жилийн II дунд сургууль төгсөөд, 1951 оноос багшийн сургуульд суралцаж, 1954 оны 9 дүгээр сараас Улсын Хөгжимт драмын театрт орж, алыг хөгжимчин, удирдаач, 1962 оноос Хөгжим бүжгийн дунд сургуульд томилогдон хөгжмийн онол, үндэсний найрал, цөөхүүл хөгжим, хийлийн чуулга, ятга, шанз, хуучрын төрөлжсөн чуулга, багшлах дадлага, удирдаач, шударга хөгжмийн ардын арга барил зэрэг хичээлүүдийг зааж байсан байна. Д.Дарьзав нь 1954 оноос монголын соёл урлагийн салбарт зүтгэхдээ удирдаач, хийлч, багш хийхээс гадна шударгадах уламжлалт арга барилыг өвлөсөн өвлөн уламжлагч, авьяаслаг шударгач байжээ. Тэрээр Улсын Хөгжимт

драмын театрт шударгач, хийлч, МУГЖ С.Базаррагчаа, С.Мядагбадам нартай мөр зэрэгцэн ажиллаж байхдаа шударга хөгжмийг өөрийн хүсэл сонирхлоор сурсан ба ХБДС-д алдарт Гавьяат хөгжимчин, лимбэч, шударгач Л.Цэрэндорж багшаас олон сайхан ардын дууг сурч, ур чадвараа хөгжүүлэн, олон арван ардын дуу хөгжмийг өөрийн гэсэн өвөрмөц донж маяг, хэв намба, хэмнэл, нугалаа, эгшиглээгээр урлан хөгжимдөж монголын радиогийн алтан санд бичүүлсэн байна.

Д.Дарьзав багшийн тухай шавь нар (Намжилмаа 2019), (Даваа 2019), (Оюунчимэг 2022), үр хүүхдүүдтэй (Жаргал 2019) хийсэн ярилцлага байх ба мэргэжил нэгт ахмад шударгач С.Бүтэд бичихдээ “Д.Дарьзав их хөнгөн шаламгай хөдөлгөөнтэй, нүд нь түүний дотоод сэтгэлийг илчлэх мэт санагдана. Монгол ардын дууны болон хөгжмийн бүтээлийн цуглуулга ихтэй, ардын цөөхүүл ба найрал хөгжимд мөн ч олон хөрвүүлэг, найруулга хийсэн. Тэрээр уран бүтээлчдээс гадна уран сайханчидтай элэгсэг харьцаж, тэдний урлагийн тоглолт, уралдаан тэмцээнд сэтгэл харамгүй тусалдаг байлаа. Д.Дарьзав ихэвчлэн ятга, лимбэ, хуучир хөгжмүүдтэй хоршиж хөгжимдөх дуртайсан. Манай радиогийн алтан фондод бичүүлсэн түүний хөгжимдсөн монгол ардын дуунуудаас сонсоход Монгол Улсын гавьяат жүжигчин, ятгач П.Мөнхөө, хуучирч С.Цэвэлмаа, Л.Балдан, ёочинч Г.Дашдаваа нартай гар нийлэн хөгжимдсөн байдаг. Тэрээр шударгаар тремоль хийхдээ нэн уянгатай, задгай цохилгууд нь нэг л зөөлөн бөгөөд тодхон сонсогддогсон. Нэн ялангуяа хуучир хөгжимтэй их нийлэмжтэй хөгжимддөг байсан. Тэрээр их алиа хошин зантай, хичээл давтдаггүй сурагчдыг ардын дууны шог хошин үгээр элэглэж зэмлэхгүйгээр, тэднийг өөртөө татдагсан. Д.Дарьзав нь “Ум зандан ширээ”, “Баавар”, “Үзэсгэлэн гуа”, “Шидэн хуар” гэх мэт дуунуудыг өөрийн гэсэн донж маягаар хөгжимддөг байлаа. Шударга хөгжмөө ялимгүй урагш нь ишийг нь ташуулдуулж барьчхаад л бахдалтай гэгч нь хөгжимдөхийг нь харсан хүн өөрийн эрхгүй, шударга сурах юмсан хэмээн боддогсон” (Бүтэд 1999, 86) гэжээ.

Ахмад шударгач Д.Дарьзав 1960 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн радио концертод ёочинч Г.Дашдаваа, хуучирч С.Цэвэлмаа нартай хамтран “Соёл эрдэнэ” дууг, 1984 онд хуучирч Л.Балдангийн хамтаар “Мэлхий”, “Янжуур тамхи”, “Хөх торгон цамц”, “Хүрэн хаалгатай дэлгүүр” дуунуудыг хөгжимджээ. Эдгээр дуунуудыг хөгжимдсөн шударгын хөг, эгшиглэж буй дэвсгэр хөгийг нь үзвэл дараах байдлаар байна.

Хүснэгт 1. Д.Дарьзавын ардын дуу хөгжимдсөн шударгын хөглөгөө, дэвсгэр хөг

№	Монгол ардын дууны нэр	Шударгын чавхдасын хөглөгөө	Чавхдасын хөгийн эгшиг хоорондын зай	Эгшиглэж буй дэвсгэр хөг	Эгшиг тэмдэглэгээг буулгасан дэвсгэр хөг
1	Соёл эрдэнэ	/h-cis ¹ -gis ¹ /	Ц ² -Ц ⁵	Си их хөг/H-dur/	B - dur
2	Янжуур тамхи	c ¹ -d ¹ -a ¹		До их хөг/C-dur/	B - dur
3	Хөх торгон цамц	c ¹ -d ¹ -a ¹		До их хөг/C-dur/	B - dur
4	Хүрэн хаалгатай дэлгүүр	c ¹ -d ¹ -a ¹		До их хөг /C-dur	B - dur
5	Мэлхий	c ¹ -d ¹ -a ¹		До их хөг /C-dur/	C - dur

Дээрх хүснэгтээс харахад “Соёл эрдэнэ” дууг си их хөг/H-dur/-т хөгжимдөж байгаа ч ардын дуу хөгжимдөх барил, эгшиглээний талаас нь шинжихэд сибемоль их хөг /B-dur/-ийн барилаар хөгжимдсөн байгаа нь тодорхой байна. Тухайлбал, шударгаар хөгжимдөхөд барил болон эгшиглээ чухал. Иймд энэ талыг баримтлан эгшиг тэмдэглэгээг сибемоль их хөгт буулгав.

Мөн “Хүрэн хаалгатай дэлгүүр”, “Хөх торгон цамц”, “Янжуур тамхи” дуу нь до их хөг/C-dur/-т хөгжимдсөн сонсогдож байгаа ба сибемоль их хөг /B-dur/-ийн барил, манераар хөгжимдсөн нь илт байна.

“Мэлхий” дууны хувьд до их хөг/C-dur/-т хөгжимдсөн сонсогдож байгаа хэдий ч хөгжимдсөн барил талаас харахад фа их хөг/F-dur/- ийн байна. Иймд “Хүрэн хаалгатай дэлгүүр”, “Хөх торгон цамц”, “Янжуур тамхи” дууг сибемоль их хөгт, “Мэлхий” дууг фа их хөгт эгшиг тэмдэглэгээнд буулгасан болно. Ингэж буулгах нь шударгаар хөгжимдөх уламжлалт арга барил бодитоор уламжлагдахад чухал билээ.

Тэгвэл, дууг хэдэн бадаг, ямар цохилгоор хөгжимдсөнийг доорх хүснэгтэд тоймлон харуулья.

Хүснэгт 2. Д.Дарьзавын хөгжимдсөн арга барил

№	Дууны нэр	Хөгжимдсөн бадгийн тоо	1-р бадгийг хөгжимдсөн цохилго	2-р бадгийг хөгжимдсөн цохилго	3-р бадгийг хөгжимдсөн цохилго	4-р бадгийг хөгжимдсөн цохилго
1	Соёл-Эрдэнэ	3 бадаг	Задгай	Задгай	Задгай	
2	Мэлхий	3 бадаг	Давхар	Задгай	Давхар	
3	Янжуур тамхи	3 бадаг	Задгай	Давхар	Задгай, давхар хольж	
4	Хөх торгон цамц	4 бадаг	Давхар	Задгай	Давхар	Задгай
5	Хүрэн хаалгатай дэлгүүр	2 бадаг/4 ая/	Давхар	Задгай давхар хольж		

Дээрх хүснэгтээс ажиглахад дууны бадгуудыг цохилгын төрлүүдээр өөр хооронд нь ялгаруулан дараах хэмнэлүүдээр хөгжимджээ. Үүнд:



Зураг 2. Д.Дарьзавын давхар цохилгоор хөгжимдсөн “Мэлхий” дууны 1,3-р бадгийн хэсэг

Дан, давхар, задгай цохилгыг нэг айзамд хольж хөгжимдөх хэлбэр байна. Жишээ нь, “Мэлхий” дууны нэгдүгээр бадгийн 15-р айзам, “Хөх торгон цамц” дууны 3-р бадгийн 5-р айзам, “Хүрэн хаалгатай дэлгүүр” дууны 10,11-р айзмаас харж болно.



Зураг 3. Д.Дарьзавын задгай эгшиглээгээр хөгжимдсөн “Мэлхий” дууны 2-р бадаг



Зураг 4. Д.Дарьзавын хөгжимдсөн “Мэлхий” дууны дан болон давхар цохилго хольж хөгжимдсөн хэсэг

Зураг 5. Д.Дарьзавын давхар болон задгай цохилго хольж хөгжимдсөн “Хөх торгон цамц” дууны хэсэг



Зураг 6. Д.Дарьзавын давхар болон задгай цохилго хольж хөгжимдсөн “Хүрэн хаалгатай дэлгүүр” дууны хэсэг

Задгай болон битүү жигд эгшиглээний талаас ажиглавал, “Хөх торгон цамц” дууны 13, 29, “Мэлхий” дууны 15, 31-р айзмуудад 1-р наймцын соль эгшигийг II чавхдас дээр дарж битүү жигд эгшиглүүлсэн ба “Соёл эрдэнэ”, “Хүрэн хаалгатай дэлгүүр”, “Янжуур тамхи” дуунуудыг ерөнхийд нь задгай эгшиглээгээр хөгжимджээ.



Зураг 7. Мэлхий дууны хэсэг



Зураг 8. Хөх торгон цамц дууны хэсэг

Ардын дууг хөгжимдсөн байдлыг хэмнэл талаас ажиглавал, “Соёл эрдэнэ” дуунаас бусад дуунуудад арванзургаатын давхар цохилгыг өргөн хэрэглэжээ. Үүгээрээ бусад шударгачдаас ялгаатай байна.



Зураг 9. Д.Дарьзавын давхар цохилгоор хөгжимдсэн “Мэлхий” дууны хэсэг

“Соёл эрдэнэ”, “Янжуур тамхи” дууны задгай цохилгоор хөгжимдсэн бадгуудад наймт арванзургаатын хэмнэлийг цөөн тоогоор хэрэглэсэн ба “Мэлхий”, “Хөх торгон цамц”, “Хүрэн хаалгатай дэлгүүр” дууны задгай цохилгоор хөгжимдөх бадгуудыг арванзургаатын хэмнэлээр тасралтгүй эгшиглүүлэн хөгжимджээ. Дээрх таван дууны бадгуудын төгсгөлийг наймт хэмнэлээр хөгжимдсэн байна. Тод, эрэмгий, ганган цохилгоор задгай эгшиглээгээр хөгжимдөх байдал нь МУГЖ С.Базаррагчаатай нэлээн төстэй байна. С.Базаррагчаа “Ганьхуар цаас”, “Аргагүй амраг”, “Хандармаа”, “Сүнжидмаа”, “Янлинхуар”, “Сэр сэр салхи” зэрэг дуунуудыг задгай эгшиглээгээр хөгжимдсэн байдаг.

Д. Дарьзавын шударгаар
хөгжимдсэнийг ноотлов.

Хурдавтар




Зураг 10. Д.Дарьзавын хөгжимдсэн “Соёл эрдэнэ” дууны эхний хэсэг



Зураг 11. “Янжуур тамхи” дууны хэсэг

Аялгууг чимэглэн хөгжимдөх байдлыг шинжин үзвээс, I чавхдасын задгай эгшиглээг “Мэлхий”, “Янжуур тамхи”, “Хөх торгон дээл”, “Хүрэн хаалгатай дэлгүүр”, II чавхдасын задгай эгшиглээг “Мэлхий” дууны тодорхой айзмуудад хэрэглэж чимэглэн хөгжимдсэн байна.



Зураг 12. Д.Дарьзавын хөгжимдсэн “Янжуур тамхи” дууны хэсэг



Зураг 13. Д.Дарьзавын хөгжимдсөн “Мэлхий” дууны хэсэг

Харин III чавхдасын задгай эгшиглээг суурь болгон баяжуулж хөгжимдөх аргыг “Янжуур тамхи”, “Хөх торгон дээл”, “Хүрэн хаалгатай дэлгүүр” дууны зарим айзмуудад хэрэглэжээ.



Зураг 14. Д.Дарьзавын хөгжимдсөн “Хөх торгон дээл” дууны хэсэг

Аялгууг нугалаагаар чимэглэн хөгжимдсөн байдлыг ажиглавал, тухайн айзам дахь аялгууны үндсэн эгшигийг бусад эргэн тойронд байгаа эгшгээр баяжуулан, гулсалтаар холболт хийн аялгууны дараагийн үндсэн эгшигт хүрэх байдлаар нугалааг гаргаж хөгжимджээ. Үүнийг “Мэлхий”, “Янжуур тамхи”, “Хөх торгон цамц”, “Хүрэн хаалгатай дэлгүүр” дуунуудад өргөн хэрэглэсэн байна. Энэхүү нугалааг хөгжимдөхдөө баруун гарын арванзургаатын давхар цохилго, зүүн гарын III хурууг солихгүйгээр хөгжимдөхийг хослуульжээ. Гулсалтаар холбогдож байгаа эгшгүүдийн хоорондын зай хол ойр янз бүр байна. Жишээ нь, “Мэлхий” дууны 6-р айзамд 2-р наймцын фа эгшгээс солийг давж ля-г аваад ре эгшигт гулсалтаар холбож хүрэх, “Хөх торгон цамц” дууны 9-р айзамд 2-р наймцын фа эгшгээс солийг давж сибемолийг аваад ре эгшигт гулсалтаар холбож хүрэх байдлаар нугалааг үүсгэжээ.



Зураг 15. Д.Дарьзавын хөгжимдсөн “Мэлхий” дууны 5,6-р айзам



Зураг 16. Д.Дарьзавын хөгжимдсөн “Хөх торгон цамц” дууны 9-р айзам

Мөн дээрх нугалааг баруун гарын арванзургаатын задгай цохилго, зүүн гарын I хурууг хослуулан хөгжимджээ. Жишээ нь, “Янжуур тамхи” дууны 7-р айзам.



Зураг 17. Д.Дарьзавын хөгжимдсөн “Янжуур тамхи” дууны 6,7-р айзам

Аялгууны үндсэн эгшгийн олон давталтыг тохирох эгшгээр сольж баяжуулан нугалааг гаргажээ. Үүнд “Соёл эрдэнэ” дууны 1, 2, 5, 6, 7, “Янжуур тамхи” дууны 8, 13, 14-р айзам гэх зэрэг нэлээн олон жишээ байна.



Зураг 18. “Соёл эрдэнэ” дууны үндсэн аялгуутай харьцуулсан 1,2-р айзам



Зураг 19. “Соёл эрдэнэ” дууны дууны үндсэн аялгуутай харьцуулсан 5,6,7-р айзам



Зураг 20. “Янжуур тамхи” дууны 13,14-р айзам

Чимэглэнгийн дараагийн хэлбэр болох айзмын эхний хувьд болон дунд байгаа эгшгийг гулсалтаар чимэглэн хөгжимдөх хувилбарыг бага хэрэглэсэн байна. Жишээ нь, “Соёл эрдэнэ” дууны 24-р айзамд 2-р наймцын фа эгшгийг ре-гээс, “Мэлхий” дууны 14-р айзмын 1-р наймцын солийг ре-с, 15-р айзмын 1-р наймцын ми-г фа-с, “Янжуур тамхи” дууны 9, 11-р айзмын ре-г фа эгшгээс тус тус гулсалт хийж хөгжимдсэн байна.



Зураг 21. “Янжуур тамхи” дууны хэсгээс



Зураг 22. “Мэлхий” дууны дунд хийсэн гулсалт



Зураг 23. “Янжуур тамхи” дууны хэсгээс

Дээрх судалгаанаас харахад Д.Дарьзав нь цохилгын төрлүүдээр ялгаруулан хөгжимдөх, шударгын сул гурван чавхдасын задгай эгшиглээ, үндсэн эгшгийн өмнөх болон дараагийн эгшгүүдээр чимэглэн нугалаа гаргах, арванзургаатын давхар цохилго, зүүн гарын хуруу солихгүй, гулсалтаар эгшгүүдийг холбож нугалаатай хөгжимдөх, эхний болон дунд хувьд байх эгшгүүдийг шулуун гулсалтаар чимэглэх зэрэг шударгын уламжлалт арга барилаар хөгжимдөх онцлог аргуудыг тохирох газруудад оруулан чадварлаг хөгжимдсэн байна. Харин чимэглэх аргын нэг хэлбэр болох цувраа болон зүүн гарын чичиргээг огт хэрэглээгүй нь ажиглагдлаа.

Хэлэлцүүлэг

Эдүгээ монголын шударга хөгжимчдийн хөгжимдөх арга барилын талаар ихээхэн бичиж үлдээсэн хүн бол Төрийн шагналт, АЖ, багш Ц.Дашдулам юм. Тэрээр бичихдээ “Л.Цэрэндорж багш “Үлгэрийн холбоо” гэж нэрлэдэг аялгууг гоц хөгжимдөнө. Ардын дууг дан цохилгоор онцгой сайн хөгжимддөг хүн. Энэ хүнийг шударга хөгжмөөр хөгжимдөх манай үеийн дэг сургуулийг үндэслэгчийн нэг гэж бүрэн хэлж болмоор байдаг. Дан цохилгыг Д.Ишдулам, З.Буяндэлгэр, О.Дашдэлэг нар сайн хийдэг байсан юм. Тэр дундаа Л.Цэрэндорж багшийн хөгжимдөлт онцгой уран, гоёмсог байдгийг дахин тэмдэглэх хэрэгтэй” хэмээн цохилго болон эгшиглээний талаас дүгнэн бичсэн байдаг. Тэрээр цааш бичихдээ “Баяр багш

(солгой Баяр гэж алдаршсан)-ийн хөгжимдөхөд баруун гарын цохилгоны дуунаас зүүн гарын даралтын дуу нь тод сонсогдож морин төвөргөөн адил дэжигнэж байдгийг одоо гайхаад олохгүй юм. Миний багш Баярын давхар цохилго үг хэлж байгаа юм шиг тов тодорхой сонсогддог байсан нь бусдаас илүү ой тоонд үлджээ” хэмээн баруун зүүн гарын хүч, цохилгын төрлүүдийг гүйцэтгэх байдал, эгшиглээний талаас ажигласнаа бичжээ.

Мөн цохилгыг гүйцэтгэх талаар бичихдээ “Цохилго болон даралт хэдий чинээ жигдрэх тутам дууны ая үг сонсогдож байгаа юм шиг тодорхой болдог. Энэ цохилгыг гарамгай хийдэг хөгжимчний нэг С.Базаррагчаа юм. МУГЖ С.Базаррагчаагийн баруун гарын хаялга сайн, аялгууг илэрхийлэх уран гоё нугалаа, үсрэлт нь бусдаас илүү баялаг сонсогддог. Гавьяат жүжигчин Базаррагчаа монгол ардын дууг задгай цохилгоор хийхдээ гоц хүн. Учир нь шударга хөгжмийн боломжийг хамгийн өргөн ашиглаж ардын дууны аяыг гоён гангалж, улам эрхэмсэг болгож чаддаг юм” гээд “Хүрээ маягийн ая гарган дууг өөрөө дуулан шударгадахдаа АЖ Д.Ичинхорлоо, Т.Хандсүрэн, МУГЖ С.Лувсангомбо нар ч их сонирхол татаж байлаа. Энэ дуучид аяны намбад цохилго, хүчийг их сонирхолтой тааруулдаг байлаа” хэмээн цохилго, түүнийг гүйцэтгэх байдал, хоёр гарын хүч, түвшин, эгшиглээний чанар зэргийг хүн бүрээр тодруулахыг хичээн бичиж үлдээжээ.

Ахмад шударгач, багш С.Бүтэд монголын орчин цагийн хөгжмийн урлагийн зүтгэлтэн Д.Ишдулам (1870-1947)-аас С.Гомбо (1937-1998) хүртэлх 30 шударгачийн амьдрал уран бүтээл, хөгжимдөх онцлогийг ерөнхийд нь судлан бичсэн байна. Эдгээр судалгааг гүнзгийрүүлэн нарийвчилж, ХХ зууны эхний хагасад бэлтгэгдсэн ахмад үеийнхний хөгжимдөх арга барил, уламжлал дараагийн үед хэрхэн өвлөгдсөн, хөгжсөн онцлогийг тодруулах үүднээс ахмад багш, шударгач Д.Дарьзавын хөгжимдөх арга барил хөгжимдөлтийг хөг хөглөгөө, цохилго, хэмнэл, эгшиглээ, донж маяг, чимэглэлийн төрлүүд талаас нь судалж бичсэн болно. Цаашид энэхүү судалгааг үргэлжлүүлэн бусад ахмад хөгжимчдийн арга барилыг судлах шаардлагатай.

Дүгнэлт

Д.Дарьзав шударгач ардын дууны хөг /И²-Ц⁵/-өөр хөгжимдөх уламжлалт арга барилыг чадамгай эзэмшсэн, өвлөн уламжлагч байжээ. Д.Дарьзавын дан, давхар задгай цохилгыг ямар ч тээргүйгээр хольж хөгжимдөх, арванзургаатын хэмнэлээр задгай эгшиглээг тод цохилготой, жигд, шулуун хөгжимдөх зэрэг хөгжимдөлт нь шударгач Л.Цэрэндорж, С.Базаррагчаа нарын хөгжимдөлтэй нэлээн төстэй байгаа нь ажиглагдаж байгаа ба тэдний арга барилаас суралцан уламжилсан гэдэг нь тодорхой байна.

Мөн өөрийн авьяас билэг, мэдрэмжид тулгуурлан аялгууг их эвдэхгүйгээр энгийн байдлаар цохилгын төрлүүд, гулсалт, нугалаа, сул чавхдасын задгай эгшиглээ, эгшиг баяжуулалт зэрэг янз бүрийн хэлбэрээр чимэглэн баяжуулж, ардын дууны аялгууг гоён гангалж, эрхэмсэг болгон чадварлаг хөгжимдсөн байна.

Дээрх аргуудаас гадна авиалаг шинж бүхий донж маяг, дуу бүрийн онцлог, хэв маягийг мэдэрч хэмнэл, хурд, цохилго, чимэглэлийг зөв сонгож, тохирох газарт

байрлуулан хөнгөн, цэмцгэр, хурдтай, жигд эгшиглээтэй уран хөгжимддөгөөрөө бусад шударгачдаас ялгарч байна. Энэхүү ялгаралт нь Дарьзавын арга барил гэж үзэж болох хэв маягийг бий болгосон байна.

Ингэж чадварлаг, уран, цэмцгэр хөгжимдөж байгаа нь түүний удирдаачийн мэргэжил, сонгодог хөгжимдүүр эзэмшсэн байдал, мөн эрэгтэй шударгачийн баруун, зүүн гарын жигд хүч, төрөлхийн авьяас билэг, мэдрэмж, гарын уртай холбоотой хэмээн үзлээ.

Цаашид монголын алдарт, ахмад шударгачдын хөгжимдөх арга барилыг ийнхүү нарийвчлан судалж монголын шударгадах уламжлалт онцлог, арга барилыг тодорхой болгон хойч үеийнхэнд өвлүүлэн үлдээх, хөгжүүлэх нь монголын хөгжим судлалын салбарт зохих хувь нэмрээ оруулна хэмээн үзлээ.

Ашигласан материалын жагсаалт

- Бүтэд, С. 1999. *Монголын шударга хөгжимчид*. Улаанбаатар.
- Дашдулам, Ц. 1990. *Шударгаар хөгжимдөх ардын арга барил*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Дашдулам, Ц. 2009. *Шударгадах уламжлах урлаг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Жаргалмаа, Д. 2010. *Шударгын цохилго*. Улаанбаатар: Чөлөөт монгол.
- Оюунбат, Р. 2005. *Хүрээ дуу хөгжмийн үүсэл хөгжил*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Оюунчимэг, Л. 1995. “Шударгын түүхэн уламжлал, монгол дэгийн асуудал.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Оюунчимэг, Л. 2005. *Шударгын арван найман ая хөг*. Улаанбаатар: Сод пресс.
- Энх-Амгалан, С. 2018. *Монгол Улсын АГХ.Л.Цэрэндоржийн шударгаар хөгжимдөх ардын арга барил*. Улаанбаатар: Арилдал.
- Энх-Амгалан, С. 2018. *Шударгын жудар, хуурын татлагын ая аялгуу*. Улаанбаатар: Арилдал.
- Энх-Амгалан, С. 2022. *Шударгаар хөгжимдөх ардын арга барил*. Улаанбаатар: Линограф.

Ярилцлага:

- ҮУИТ-ын шударгач Ш.Даваатай хийсэн ярилцлага. Улаанбаатар, 2019.01.2.4.
- Дарьзавын охин Жаргалтай хийсэн ярилцлага. 2019.01.10.
- ҮУИТ-ын шударгач Д.Намжилмаатай хийсэн ярилцлага. Улаанбаатар, 2019.01. 23.

Дүрс бичлэг:

Оюунчимэг, Лувсанноров. 2022. “Эгшиглэнт мөр.” Намтарчилсан нэвтрүүлэг.
01:20, 2022.05

Аудио бичлэг:

Дарьзав, Д. 1960. *Соёл эрдэнэ*. МҮОНРТВ. Ардын дууны аудио бичлэг.

Дарьзав, Д. 1984. МҮОНРТВ. Ардын дууны аудио бичлэг.